



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/671

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулах, хянуулж, зөвшөөрөл авахаар Улаанбаатар хотод ажиллах зардалд 5724800 төгрөг, төрийн захиргааны ахмад ажилтнуудын гадаад харилцааны арга хэмжээг дэмжих зардалд 1500000 төгрөгийг тус тус баталж, зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 7224800 төгрөг /Долоон сая хоёр зуун хорин дөрвөн мянга найман зуу/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.29-д тусгагдсан Төрийн үйлчилгээний ISO 9001 стандартыг нэвтрүүлэх, "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/671 Gh  
02 03346